МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ 2024 ОН

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 1.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн. | Байгууллагын (gemtel.mn) цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл<br>ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж, баяжуулалтыг хийж хөтлөн явуулдаг.<br>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль,<br>Эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг төвийн цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.<br>Эрхэм зорилго: Олон улсын стандартад нийцсэн гэмтэл согогийн цогц тусламж үйлчилгээг эрсдэлгүй, ээлтэй орчинд мэргэшсэн хамт олон тэгш, найрсаг үйлчилгээгээр хүртээмжтэй үзүүлнэ.<br>Төвийн хэмжээнд үйл ажиллагааны чиглэл бүрээр Олон улсын стандарт шаардлага хангасан байх зорилт тавьсан.<br>Төв болон салбар эмнэлгийнхэмжээнд ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилтийг тогтмолжуулж ажиллах зорилтын хүрээнд хагас жилийн дотоод аудитыг ГССҮТ-ийн захирлын 2024-05-16 А/69 тоот тушаалын дагуу 2024-06-10 өдөр төвд, 2024-06-11 нд салбар эмнэлэгт хагас жилийн дотоод аудитыг гүйцэтгэсэн. Бүтэн жилийн дотоод аудитыг 2024-09-25 А/122 тоот тушаалын дагуу 2024-11-04 өдөр төвд, 2024-11-05 нд салбар эмнэлэгт тус тус зохион байгуулагдсан байна. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Монсертф ХХК -иас 2024 оны 11 дүгээр сарын 18-19 ний өдрийн хоононд Чанарын менежментийн тогтолцоо магадлах 1 баталгаажуулалтын гадаад аудит зохион байгуулагдсан.<br>MNS 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо,шаардлага стандартын сургалтад 2 мэргэжилтэн хамрагдаж гэрчилгээ авсан байна.<br>“Аму консалтинг ХХК”-р төвийн хэмжээнд 7101:2023 стандартын зөрүүний дүн шинжилгээг хийлгэж 06 сарын 17 ажилчдын дунд хурлыг зохион байгуулан дүгнэлтийг танилцуулсан. 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо шаардлага стандартыг хэрэгжүүлэх гэрээг 2023.06.14 “Аму консалтинг” ХХК-тай байгуулаж тус стандартын танилцуулга хичээлийг төвийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.<br>ГССҮТ-н Захирлын 2024.01.22 А/17 тоот тушаалаар төв болон салбар эмнэлгийн хэмжээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлын хэсэг”, 2023.12.26 А/161 тоот тушаалаар “Үйлчлүүлэгчийн дэмжих орон тооны бус зөвлөл” тус тус байгуулагдсан.<br>ус ажлын хэсгийн хүрээнд төв болон салбар эмнэлэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан нэгдсэн ГССҮТ-н эмнэлгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулан төвийн захирлаар батлуулаж хэрэгжилтийг хангаж ажиллаа. MNS 7014:2023 стандартын “Эмнэлгийн ажилтан бүр хөтөч” аяныг 2024.04.01-06.01 хооронд зохион байгуулаж, Төв болон Салбар эмнэлэгт Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын танилцуулга хичээл, шинээр ажилд орсон нийт 197 эмч, ажилтан мөн 25 резидент эмч нарт шинэ ажилтны чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн ГССҮТ-н захирлын 2023.11.08 А/130 тоот тушаал ГССҮТ-н гадна, дотно хаягжилтын ажлын хэсэг байгуулан үйл ажиллагааг 2 дугаар улиралд 100% гүйцэтгэн ажилласан.<br>2024 оны 8 сард мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн ба зөвлөмжийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | ISO/IEC27001:2015 ийг нэвтрүүлэх төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу “System center” ххк-тай хамтран гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. | |
| 1.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг. | Гэмтэл согог судлалын үндэсний төв нь гэмтэл согогийн чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэшлийн арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг юм.<br>**Төв эмнэлэг:**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, 16092, Баянгол дүүрэг, 31 дүгээр хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж Утас: 7711-5111<br>**Салбар эмнэлэг:**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, 14192, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо<br>Ж.Батмөнхийн гудамж<br>Утас: 77770136<br>БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ<br> | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Тус төв нь 2024 оны 09 дүгээр сард Юнивишн ХХК-тай хамтран колл центр байгуулан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаа.<br>1. Төвийн үндсэн лавлах - 77115111<br>2. Салбар эмнэлэг - 77770136<br>Байгууллагын албан хэргэцээнд ncto@gemtel.moh.gov.mn Цахим шуудангийн хаяг ашиглан ажиллаж байна.<br>Эмнэлгийн үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөмж зөвөлгөө хүргэх чиглэлийн хүрээнд facebook page хуудсанд өдөр бүр шинэ мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. https://www.facebook.com/gemtelsogog<br>Тус төв нь 2024 онд өөрийн цахим хуудсыг бие даан хөгжүүлж одоогоор 100% гүйцэтгэлтэй ажиллаж байна. Цахим хуудсыг шинэчилсэнээр мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, хийгдэж байгаа эмчилгээ, мэс заслын танилцуулга, боловсон хүчний дэлгэрэнгүй танилцуулга, ил тод байдлын үзүүлэлтүүдийг багтаасан цахим хуудсыг шинээр баяжуулан ажиллаа. | |
| 1.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | 2024 оны нэгдүгээр хагасын үйл ажиллагааны тайлан ба монгол улсын хэмжээнд ашиглагдаж буй осол гэмтлийн шалтгаант өвчлөл нас баралт, тэргүүлэх шалтгаан зэргийг цахим хуудас дахь үйл ажиллагаа цэсэнд байршуулсан байна. 2023 оны Аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2024 оны 07 сарын 02-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт мэдээлсэн.<br>Санхүүгийн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан ба тухайн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>1. 6 зөвлөмж өгсний 6 зөвлөмжийг 100%,  биелүүлсэн.<br>Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>2024 оны батлагдсан төсөв 73,701,560.10 төгрөг бөгөөд зардлын бүлэг тус бүрээр шилэн дансны вэб сайтад байршуулсан. зардлын ангилал тус бүрээр 2023.01.10-ны өдөр байршуулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2024 онд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан ба тухай бүр нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад байршуулан хуулийн хугацаанд шалгаруулалтыг нээлттэй зарлан үр дүнг нийтлэн ажилласан.<br>Нээлттэй тендер шалгаруулалтаар – 33,102,700.0 мянган төгрөг<br>Харьцуулалтын аргаар – 491,000.000 мянган төгрөг<br>Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл, лабораторийн урвалж худалдан авах – 10,2 тэрбум төгрөг, Хүнсний материал худалдан авах – 600 сая төгрөг, Өндөр өртөгт мэс заслын хэрэгсэл худалдан авах – 11,5 тэрбум төгрөгний нээлттэй тендер, хангамжийн материал худалдан авах тендерийг зардал тус бүрээр тендер шалгаруулахаар төлөвлөсөн ба төлөвлөгөөг шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, tender.gov.mn сайт тус тус хуулийн хугацаанд мэдээлсэн. | |
| 1.4 | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. | Ил тод байдлын тухай хуульд заасны дагуу цахим хуудас болон эмнэлгийн пэйсбүүк пэйж хуудас, https://shilendans.gov.mn сайтуудад тухай бүр үйл ажиллагааны тайлан, статистик тоон үзүүлэлтүүд болон санхүүгийн дүгнэлт, тендерийн үнэлгээний хорооны тушаал шийдвэр, зэргийг хавсарган ажиллаж байна.<br>2024 оны Ажилтан алба хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэ хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилэн байгуулсан; | 100% |
| 1.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг ханган ажилласан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт. | Монгол Улсын эрүүл мэндийн салбарын үйл ажиллаганд мөрдөгдөж байгаа нийт 114 хууль тогтоомжоос Гэмтэл согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 100 хууль, эрүүл мэндийн салбарт нийтлэг мөрддөг 14 хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.Үүнээс:<br>Тухайн салбарт мөрдөгдөж байгаа хууль<br>- Гэмтэл согог судлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр - 29<br>- Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр - 15<br>- Биотехнологи инновацын чиглэлээр - 9<br>- Тархвар зүй, шуурхай удирдлагын чиглэлээр - 6<br>- Санхүү аж ахуйн чиглэлээр -16<br>- Хоол, шим тэжээл судлал, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр - 8<br>- Лаборатори, оношилгоо шинжилгээний чиглэлээр – 1<br>- Тархвар зүй, шуурхай удирдлагын чиглэлээр – 6<br>Нийтлэг мөрддөг хууль<br>- Биеийн тамир, спортын тухай хууль<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль<br>- Хог хаягдлын тухай хууль<br>- Хувь хүний нууцын тухай хууль<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль<br>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль<br>- Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хууль<br>- Дархлаажуулалтын тухай хууль<br>- Донорын тухай хууль<br>- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль<br>- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль<br>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль<br>- Эрүүл ахуйн тухай хууль<br>- Эрүүл мэндийн тухай хууль<br>-Төсвийн тухай хууль | |
| 1.7 | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2024 оны 01 дугаар сарын 02 -ний өдрийн А/01 тоот тушаалаар Мэдээлэл технологийн албаны дарга Эрдэнэбаярын Батдоржыг Ил тод байдлын ажилтнаар ажиллуулж байна.<br>Эрдэнэбаярын Батдорж<br>Холбоо барих дугаар: 88020213, 77115111<br>Цахим шуудангийн хаяг: batdorj.e@gemtel.moh.gov.mn | 100% |
| 1.8 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | ГССҮТөв нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалын “Иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх журам”, ГССҮТ-н ЕЗ-н 2023 оны 11 сарын 08-ны А/128 “Өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам” -г тус тус дагаж мөрдөн ажилладаг болно.<br>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба нь иргэд, үйлчлүүлэгчдээс биечлэн, бичгээр, цахим, утсаар, 11-11 төвөөр ирсэн нийт өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажилладаг бөгөөд 2024 оны 01-11дугаар сарын хугацаанд төв эмнэлгийн хэмжээнд **100** /Төв **100%,** өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэн ажилласан байна.<br>**Өргөдөл, гомдол:**<br>• 11-11 төвөөр -62<br>• Бичгээр –25<br>• Албан бичгээр -3<br>• Цахимаар – 10<br>• Утсаар – 0 | 100% |

1. Өргөдөл, гомдлын хэлбэр

**Хүснэгт-1**

| Өргөдөл, гомдлын хэлбэр | 2024.01-11 | | 2023 он | |
|---|---|---|---|---|
| | **100** | **100%** | **126** | **100%** |
| **11-11 төвөөр** | **62** | 62% | 63 | 50.81% |
| **Бичгээр** | **25** | 25% | 30 | 24.19% |
| **Албан бичгээр** | **3** | 3% | 0 | 0% |
| **Цахимаар** | **10** | 10% | 4 | 3% |
| **Утсаар** | 0 | % | 4 | 3.23% |
| **Бусад** | 0 | % | 23 | 18.5% |

2024.01-11 сар хүртэл нийт **100** өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс бичгээр 11-11 төвөөр **/62 % /** өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна

2. Өргөдөл, гомдлыг сараар нь

**Хүснэгт-2 /2024 оны 01-11 сар хүртэлх/**

| № | Өргөдөл, гомдлол | 11-11 | Бичгээр | Албан бичгээр | Цахимаар | Утсаар | Бусад | Нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | I сар | 11 | 1 | | | | | **12** | **12%** |
| 2 | II сар | 11 | 2 | | | | | **13** | **13%** |
| 3 | III сар | 4 | | | 2 | | | **6** | **6%** |
| 4 | IV сар | 11 | | | | | | **11** | **11%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | V сар | 7 | 2 | 2 | 2 | | | **13** | **13%** |
| 6 | VI сар | 6 | 4 | 1 | | | | **11** | **11%** |
| 7 | VII сар | 5 | 3 | | | | | **8** | **8%** |
| 8 | VIII сар | | 6 | | | | | **6** | **6%** |
| 9 | IX сар | 7 | | | | | | **7** | **7%** |
| 10 | X сар | 2 | 1 | | 4 | | | **7** | **7%** |
| 11 | XI сар | 6 | | | | | | **6** | **6%** |
| 12 | XII сар | | | | | | | **0** | **0%** |
| **Нийт** | | 43 | 50 | 9 | 3 | 4 | 0 | **100** | **100%** |

2024 оны 11 сар хүртэлх Өргөдөл, гомдлыг сараар нь ангилж үзэхэд **II, X** сарууддад хамгийн их буюу нийт өргөдлийн **13** буюу **13%-**г эзэлж байна

**Хүснэгт-3 /2023-2024.01-11 сар хүртэлх өргөдөл гомдлыг сараар нь/**

| **№** | **Өргөдөл, гомдлол** | **2023 он** | | **2024.01-11 сар хүртэл** | |
|---|---|---|---|---|---|
| 1 | I сар | 6 | **4.84%** | 12 | **12%** |
| 2 | II сар | 9 | **7.26%** | 13 | **13%** |
| 3 | III сар | 7 | **5.65%** | 6 | **6%** |
| 4 | IV сар | 5 | **4.03%** | 11 | **11%** |
| 5 | V сар | 6 | **4.84%** | 13 | **13%** |
| 6 | VI сар | 17 | **13.71%** | 11 | **11%** |
| 7 | VII сар | 3 | **2.42%** | 8 | **8%** |
| 8 | VIII сар | 22 | **17.74%** | 6 | **6%** |
| 9 | IX сар | 16 | **12.90%** | 7 | **7%** |
| 10 | X сар | 13 | **10.48%** | 6 | **6%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | XI сар | 12 | **9.68%** | 7 | **7%** |
| 12 | XII сар | 8 | **6.45%** | | **0%** |
| **Нийт** | | **124** | **100%** | **100** | **100%** |

2023-2024 оны 11 сар хүртэлх Өргөдөл, гомдлыг сараар нь ангилж үзэхэд 2023 оны **VII** сард **22 /17.74%/,** 2024 оны хагас жилд **II** -X сар хамгийн их буюу нийт өргөдлийн **13** буюу **13%-г** эзэлж байна




| № | Төрөл | Өргөдөл, гомдлын нийт тоо | Нийт эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 17 | 17% |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Дүрс оношилгооны тасаг | 7 | 7% |
| 2 | Амбулаторийн тасаг | 7 | 7% |
| 4 | Статистик тандалт судалгааны алба | 5 | 5% |
| 5 | Хүүхдийн мэс заслын тасаг | 5 | 5% |
| 6 | Яаралтай тусламжийн тасаг | 11 | 11% |
| 7 | Мэдээлэл технологийн алба | 4 | 4% |
| 8 | Хавсарсан гэмтлийн мэс заслын тасаг | 5 | 5% |
| 10 | Насанд хүрэгсдийн мэс заслын тасаг | 3 | 3% |
| 9 | Гар сарвууны мэс заслын тасаг | 5 | 5% |
| 11 | Толгойн мэс заслын тасаг | 3 | 3% |
| 12 | Нурууны мэс заслын тасаг | 2 | 2% |
| 13 | Салбар эмнэлэг | 12 | 12% |
| 14 | Салбар ЯТТ | 5 | 5% |
| 16 | Салбар Амбулатори | 3 | 3% |
| 15 | Салбар СГТ | 2 | 2% |
| 17 | Салбар ТТ | 2 | % |
| 18 | Салбар НСМЗТ | 2 | % |
| **Нийт** | | **100** | **100.00%** |

**Дүгнэлт:**

1. 2024.01-11 сар хүртэл нийт 100 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 11-11 төвөөр 62 /62%/ өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна

   2023 онд 11-11 төвөөр 63 өргөдөл, гомдол ирсэн нь 2024 оны хагас жилийн өргөдөл, гомдлын тоотой харьцуулахад дөхүү тоон үзүүлэлттэй байгаа нь 2024 оны бүтэн жилийн хугацаанд нэмэгдэх магадлалтай байна.

| | | | |
|---|---|---|---|
| | | Энэ нь нөгөөтэйгүүр иргэд 11-11 төвөөр өргөдөл, гомдол өгдөг урсгалыг харьцангуй мэддэг болсонтой холбоотой жил бүрийн тоо нэмэгдэж байж болно<br>2. 2024.01-11 сард Өргөдөл, гомдлыг сараар нь ангилж үзэхэд VII, сар хамгийн их буюу нийт өргөдлийн 8 /23.5%/-г эзэлж байна.<br>2023 онд VI сард 16, VIII сарууддад хамгийн их 22 өргөдөл, гомдол ирсэн байна.<br>3. 2024.01-11 сард Өргөдөл, гомдлын утгын 23.5% /22/-г харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, 7 буюу 20.5%-г Эмчилгээ, үйлчилгээний тайлбар хангалтгүй хийснээр иргэн буруу ойлголттой гомдол гаргах өргөдөл, гомдолын утга илүү тоон үзүүлэлттэй эзэлж байна<br>2023 онд Харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой 6 өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна<br>4. Тасаг албаар нь ангилж үзэхэд Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдол нийт өргөдлийн /тасаг, эмч, ажилтан дурдаагүй болон хувь ажилтан, тасагруу чиглэсэн биш эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдөл гомдлын утгууд/ 23,5%-г эзэлж байна тасгаас ДОТ-н MRI, КТГ шинжилгээний эвдрэл, гэмтэл, хүлээгдэлтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо 6 буюу 17,6-г их тоон үзүүлэлттэй байна | |
| 1.9 | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл | ГССҮТөвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний мэдээг өдөр тутам бүхий л тасаг нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн “gemtel.mn” байгууллагын вэб сайт, “Гэмтэл согог судлалын үндэсний төв” ФБ хуудас, Тасгийн эрхлэгч албадын дарга нарын телеграм групп, “ГССҮТөвийн эмч нар”, “Осол гэмтлийн мэдээлэл” ФБ группээр дамжуулан байгууллагын дотоод хэрэгцээнд болон олон нийтэд зориулан мэдээлж байна. Мөн өдөр тутам burtgel.mohs.mn цахим системээр дамжуулан ЭМЯ, бусад холбогдох удирдах шатны байгууллагуудад мэдээлж байгаа ба цаг үеийн онцлох үйл явдлын талаарх дүн шинжилгээ бүхий мэдээллийг холбогдох байгууллагуудад болон ГССҮТөвийн НЭМАлба, хэвлэлийн ажилтантай хамтран олон нийтэд зориулсан байдлаар бэлтгэн хүргэдэг. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тархвар зүйн судалгааг 5 жилийн байдлаар хийж, сэтгүүл болгон хэвлүүлж, хамтран ажилладаг эрүүл мэндийн салбарын болон бусад салбарын байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүдийг нотолгоонд суурилсан мэдээллээр ханган ажиллаж байна.<br>2024 оны байдлаар Монгол улсад 2019-2023 онд бүртгэгдсэн осол гэмтлийн байдалд тархвар зүйн судалгаа хийж, тайланг сэтгүүл байдлаар монгол хэл дээр 300, англи хэл дээр 100 ш хэвлүүлж, эрүүл мэндийн болон бусад салбарын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нотолгоот мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлсэн.<br>Байгууллага, хэвлэл мэдээлэл, тасаг нэгжүүдийн хүсэлтээр дүн шинжилгээт мэдээлэл 200-г бэлтгэж хүргэсэн байна. | |
| 1.10 | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | “Осол гэмтлээс сэргийлэх” мэдээ мэдээлэл<br>“Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх” мэдээ мэдээлэл<br>“Хүүхдийн аюулгүй байдал -таны хариуцлагаас”аян<br>“Цагаан сар - хариуцлага" аян зохион байгуулах<br>“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний<br>“Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнд оролцох<br>“Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нь” өдөрлөгийг тэмдэглэн зохион байгуулах<br>“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” өдөрлөгийг зохион байгуулан ажилласан.<br>“Нийслэлийн авто машингүй өдөр” өдөрлөгт оролцон ажилласан<br>“Эрүүл мэндийн технологийн үзэсгэлэн 2024” арга хэмжээнд оролцон ажиллав<br>“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан “Жаргалтай эх үрс” өдөрлөгийг зохион байгуулах<br>“Хичээлийн хэрэгсэл гардуулах өдөрлөг” зохион байгуулах<br>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан д.сүхбаатарын талбайд “Осол гэмтлээс сэргийлэх” нөлөөллийн ажлыг зохион байгуулсан<br>“Улаанбаатар марафон 2024” | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 2.1 | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Хүний нөөцийн бүрдүүлэлт сонголтын үйл ажиллагаа ажлын байрны зар, мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэх, ил тод байдлыг хангах зорилгоор дараах сайтуудад зар байршуулж байна.<br>- www.gemtel.mn<br>- www.zangia.mn<br>- www.facebook.com/Гэмтэл согог судлалын үндэсний төв<br>- www.chd.mohs.mn<br>- www.facebook/Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захиргаа хүний нөөцийн алба/групп<br>- Нийслэл, БГДүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс<br>- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв<br>ГССҮТөвд шаардлагатай орон тооны зарыг ГССҮТ-ийн мэдээллийн цахим хуудсанд 2024 онд нийтдээ 283 /давхардсан тоо/ удаа **29** ажлын байрны нээлттэй болон дотоод сонгон шалгаруулалт зарлаж, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв болон эмнэлгийн цахим хуудас www.gemtel.mn, “Гэмтэл согог судлалын үндэсний төв” www.facebook, zangia.mn ажлын байрны нэгдсэн хуудсанд тус тус байршуулж, нийт **28** ажлын байранд **220** эмч, эмнэлгийн ажилтныг сонгон шалгаруулж шаардлагатай албан тушаалд томилон ажиллаж байна. | 100% |
| 2.2 | Албан хаагч, ажилтны сонгон шалгаруулах журам | 2023 оны 12-р сарын 06-ны өдрийн А/139 тоот тушаалын 1-р хавсралтаар “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам”-ыг батласан. Мөн 2024 онд Төвийн захирлын А/66 тоот тушаалаар Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж 4.5, 4.6, 4.7 -д тус тус тусгасан болно | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | Албан хаагч, ажилтны ёсзүйн дүрэм | • Зөрчил үүссэн буюу үүсэж болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх, сургалт явуулах, эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авдаг. Үүнд: 2024 оны 1-11 сарын хооронд салбар хороонд ирсэн ажилтан болон үйлчлүүлэгчээс ирсэн 9 өргөдөл, гомдлын 7-ыг эвлэрүүлэн зуучилсан, Ёс зүйн алдаа тогтоогдсон **1 эмчид сахилгын шийтгэл оногдуулсан**, БГД-н цагдаагийн 1-р хэлтэст шалгагдаж байгаа 1 зөрчлийг шийдвэрлэх боломжгүй тул буцаасан.<br>• 4. 2024 онд Ёс зүйн салбар хорооны дарга О.Цэрэндорж, Г.Бадамгарав, А.Цэрэндолгор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм сэдэв”-т сургалтыг төв болон салбар эмнэлэгт 4 удаа зохион байгуулсан.<br>• Ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг сайжруулах үүднээс дараах сургалтыг зохион байгуулсан.<br>1. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”<br>2.“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”<br>3.“Сувилагч мэргэжилтний ёс зүйн дүрэм”<br>4.“Үйлчилгээний соёл, харилцаа хандлага”<br>5."Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадвар"<br>6."Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадвар"-ыг сайжруулах гэх мэт сэдэвээр нийт 15 удаагийн сургалтыг зохион байгуулж төвийн 980 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br>• Тайлант оны 1-11 сард шинээр ажилд орсон нийт 220 ажилтанд тухай бүр Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж ажилласан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 2.4 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Ерөнхий захирлын 2018 оны 398 тоот тушаалын дагуу Хүний нөөцийн хөгжлийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын дагуу Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн 12 дугаар сард дүгнэж хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж хэвшсэн.<br>"Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр" хэрэгжсэнээр:<br>• Хүний нөөцийн менежментийн ур чадвар бэхжинэ.<br>• Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хуваарилалтад ахиц өөрчлөлт гарч чадвартай боловсон хүчнээр хангагдана.<br>• Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар сайжирна. Тэдний ажлын бүтээмж дээшилж, Хүний нөөцийн хуваарилалт сайжирч, боловсон хүчин мэргэшсэн, тогтвортой болно.<br>Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр хүний нөөцийн судалгаа боловсронгуй болно. Уг хөтөлбөр мэдээллүүдийг цахим хаяганд байршуулсан. | 100% |
| 2.5 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | ГССҮТөвийн цахим хуудасны хууль эрх зүй цэсний "Захирлын тушаал" хэсэгт тогтмол тушаал шийдвэрүүдийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. | 100% |
| 2.6 | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийнг үнэлэх журам | Цахим хуудсандаа ажлын гүйцэтгэлийн үнэлгээний загвар, аргачлалыг шинэчлэн боловсруулж, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 06 дугаар сарын 09-ны А/59 тоот тушаалаар батлан мөрдөж, засгийн газрын тогтоолын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшууллын болзлын дагуу дүгнэн улирал тутам үндсэн цалингийн 10-20 хувийн урамшуулал олгож байгаа талаар байршуулан ажилласан. | 100% |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх | | | |
| 3.1 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг шилэн дансны вэб сайтад байршуулсан. Мөн Байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад зардлын ангилал тус бүрээр 2024.01.05-ний өдөр байршуулсан | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.2 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 03 сарын 20-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт мэдээлсэн. | 100% |
| 3.3 | Санхүүгийн тайлан хийсэн аудитын дүгнэлт | 2023 оны Аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2024 оны 07 сарын 02-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт мэдээлсэн.<br>Санхүүгийн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан ба тухайн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>1. 6 зөвлөмж өгсний 6 зөвлөмжийг 100%, биелүүлсэн.<br>Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 100% |
| 3.4 | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | ЭМД-н сангаас санхүүжих оношийн хамааралтай бүлгийн болон хувь хүний хамтын төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 06 дугаар тоот тогтоолын дагуу захирлын 2024 оны 07 сарын 22 ний № А/92 тоот тушаалыг 2022 оны 12 сарын 08-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн.<br>“Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам, жагсаалт батлах тухай“ 2023 оны 12 сарын 06-ний Ерөнхий захиралын А/147 тоот тушаалыг 12 сарын 12-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн. | 100% |
| 3.5 | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Төсвийн хэмнэлт, хэтрэлтийн талаар **853** тайлбар мэдээллийг улирал бүрийн 5-ны дотор шилэн дансны вэб сайтад байршуулсан. | 100% |
| 3.6 | Таван сая, түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | Эм бэлдмэл, өндөр өртөгт мэс засалд хэрэглэгдэх хэрэгсэл, хоол хүнс, бусад хангамжийн материалтай холбоотой худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг хавсралт 8-ын дагуу бэлтгэж 217 байгууллагын 29 тэрбум төгрөгийг шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, гүйлгээ гарсан тухай бүр тус тус хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 3.7 | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн | 2024.11.30-ны өдрийн байдлаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг долоо хоног бүр хүлээн авагчийн нэр, | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр. Гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | гүйлгээний утга, мөнгөн дүнг шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт тус тус мэдээлсэн. | |
